

СУРГАЛТЫН ТӨЛБӨР ХАРИУЦАХ ГЭРЭЭ

20... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

№

Улаанбаатар
хот

Нэг талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, албан тушаалтай,
..... овогтой /цаашид “Компани” гэх/,

нөгөө талаас: “.....” ХХК-д албан тушаалтай, овогтой
..... /цаашид “Ажилтан” гэх/ /цаашид хамтад нь “талууд” гэх/ нар харилцан
тохиролцож энэхүү “Сургалтын төлбөр хариуцах гэрээ” /цаашид “гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээгээр Компани нь Ажилтны мэдлэг боловсрол, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, хөгжүүлэх зорилгоор дотоодод богино, дунд, урт хугацаагаар их, дээд сургууль болон мэргэжлийн сургалтад хамруулан сургахдаа сургалтын төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн төлөх, Ажилтан нь амжилттай суралцаж төгссөний дараа албан тушаалд-аас доошгүй жил ажиллахтай холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээний дагуу Компани Ажилтныг улсын их, дээд сургуульд чиглэлээр, сарын хугацаанд суралцахад нь дэмжлэг үзүүлэн сургалтын төлбөрийн ... хувь буюу /...../ төгрөгийг хариуцан төлнө.
- 1.3

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээг 20.. оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн 20.. оны ... дүгээр сарын ...-ны өдөр хүртэл сарын хугацаатайгаар байгуулав.
- 2.2 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Ажилтан сургуулийг амжилттай суралцаж төгссөний дараа энэхүү гэрээнд заасан албан тушаалд, тогтоосон хугацаанд ажилласнаар дуусгавар болно.

Гурав. Гэрээний үнэ, төлбөрийн нөхцөл

- 3.1 Компаниас төлөх сургалтын төлбөрийн хэмжээг тухайн сургуулиас нийтэд зарласан хэмжээгээр буюу уг сургуулиас Ажилтанд олгосон төлбөрийн нэхэмжлэхийг үндэслэн тогтооно.
- 3.2 Компани нь сургалтын төлбөрийг сургуулиас тогтоосон хугацаанд зөвхөн тус сургуулийн дансанд тушаана.
- 3.3 Ажилтан нь энэхүү гэрээний 5.2.2-д заасан үүргийг биелүүлснээр Компани сургалтын төлбөрийг үргэлжлүүлэн төлөх ба ийнхүү биелүүлээгүй тохиолдолд Компани төлбөр төлөх үүргээ биелүүлэхээс татгалзаж болно.

Дөрөв. Компанийн эрх, үүрэг

- 4.1 Компани нь дараахь эрхийг эдлэнэ. Үүнд:
 - 4.1.1 Ажилтанд тухайн сургуулийн захиргаанаас сургуульд элссэнтэй холбогдуулан олгосон бичиг баримтын хувийг төлбөрийн нэхэмжлэхийн хамт Ажилтнаас шаардах;
 - 4.1.2 Хичээлийн жилийн улирал бүрийн эцэст Ажилтнаас дүнгийн хуулбарыг шаардах;
 - 4.1.3
- 4.2 Компани нь дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1 Гэрээний 1.2-д заасан төлбөрийг тогтоосон хугацаанд тухайн сургуулийн дансанд шилжүүлэх;
 - 4.2.2 Ажилтныг амжилттай суралцаж төгссөний дараа энэхүү гэрээгээр тохиролцсон албан тушаалаар баталгаатай хангах;

Тав. Ажилтны эрх, үүрэг

- 5.1 Ажилтан нь дараахь эрхийг эдлэнэ. Үүнд:
 - 5.1.1 Компаниас гэрээний 4.2.1-д заасан төлбөр төлөх үүргээ биелүүлэхийг шаардах;
 - 5.1.2
- 5.2 Ажилтан нь дараахь үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 5.2.1 Сургуулийн захиргаанаас олгосон бичиг баримтын хуулбарыг Компанид гаргаж өгөх;
 - 5.2.2 Сургуулиас батласан сургалтын төлөвлөгөөнд заасан мэдлэг чадварыг бүрэн эзэмшиж, идэвхи чармайлт гарган ... ба түүнээс дээш голч дүнтэй суралцах;
 - 5.2.3

Үргэлжлэл бий /4х/

